



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2011 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

┌ Харилцан холболтын орлого хуваарилах
зарчмыг хянан батлах тухай ┐

Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4, 9.1.5 заалт, Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, сүлжээ хоорондын харилцан холболтын ерөнхий журмын 10 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын цахилгаан холбооны сүлжээ хоорондын дотоод харилцан холболтын орлого хуваарилах зарчмыг хавсралтын дагуу хянан баталсугай.

Хоёр. Батлагдсан орлого хуваарилах зарчмыг 2011 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж харилцан холболтын гэрээнд тусган ажиллахыг цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчдэд үүрэг болгосугай.

Гурав. 2010 оны 01 дүгээр сарын 01-нээс 2011 оны 03 дугаар сарын 31-ны хүртэлх Цахилгаан холбооны сүлжээ хоорондын харилцан холболтын төлбөр тооцоог 2009 оны 61 дүгээр тогтоолын дагуу 2011 оны 05 дүгээр сарын 31-ны дотор бүрэн хийж дуусгахыг цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчдэд үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2009 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 61 дүгээр тогтоолын хоёр дугаар заалтад холбогдох хавсралтыг 2011 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон хүчингүй болсонд тооцсугай.

Тав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Б. Болдбаатар/-д даалгасугай.

ДАРГА

ГИШҮҮД

Б.БОЛДБААТАР

Ж.САНСАР

Ж.УРАНЧИМЭГ

Б.МӨНХБАТ

Н.БААТАРХУЯГ

Н.ЭРДЭНЭХҮҮ

А.МӨНХБАТ

(дөрөв саяангай)

Харилцаа холбооны зохицуулах
хорооны 2011 оны 23-р
тогтоолын хавсралт

**Цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчид хоорондын
харилцан холболтын орлого хуваарилах зарчим**

1. Үүрэн телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнээс үүрэн телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнд яриа төгсгөхөд харилцан холболтын орлого хуваарилах зарчим:

№	Үйлчилгээ эрхлэгч		Орлого хувиарлалт		
	Хаанаас	Хаашаа	Тариф	Яриа үүсгэгч талд	Яриа хүлээн авагч талд
1	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	xxx	(xxx-20 төг)	20 төг

2. Үүрэн телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнээс суурин телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнд яриа төгсгөхөд харилцан холболтын орлого хуваарилах зарчим:

№	Үйлчилгээ эрхлэгч		Орлого хувиарлалт		
	Хаанаас	Хаашаа	Тариф	Яриа үүсгэгч талд	Яриа хүлээн авагч талд
1	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	xxx	(xxx-20 төг)	20 төг

3. Суурин телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнээс үүрэн телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнд яриа төгсгөхөд харилцан холболтын орлого хуваарилах зарчим:

№	Үйлчилгээ эрхлэгч		Орлого хувиарлалт		
	Хаанаас	Хаашаа	Тариф	Яриа үүсгэгч талд	Яриа хүлээн авагч талд
1	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	Үүрэн телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	xxx	(xxx-20 төг)	20 төг

4. Суурин телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнээс суурин телефон холбооны үйлчлэгчдийн сүлжээнд яриа төгсгөхөд харилцан холболтын орлого хуваарилах зарчим:

№	Үйлчилгээ эрхлэгч		Орлого хувиарлалт		
	Хаанаас	Хаашаа	Тариф	Яриа үүсгэгч талд	Яриа хүлээн авагч талд
1	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	Суурин телефон холбооны үйлчилгээ эрхлэгчид	xxx	(xxx-х/т)	Харилцан тохиролцсоноор (х/т)